

ТАНИЛЦУУЛГА

Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн
түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ
хоорондын гэрээний төслийн тухай

Харилцааны түвшингийн талаар

Монгол Ардын Засгийн газар, Зөвлөлт Оросын Засгийн газрын хооронд 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр найрсаг харилцаа тогтоох тухай гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээгээр хоёр улсын хооронд харилцааны эрх зүйн үндэс анх тавигдаж, дипломат харилцаатай болсон. Түүнээс хойш Монгол Улс, ОХУ хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор ОХУ-тай улс төрийн яриа хэлэлцээг эрчимжүүлж, стратегийн түншлэл тогтоож, дээд, өндөр түвшинд харилцан айлчлал хийж ирсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1993 оны 1 дүгээр сард ОХУ-д албан ёсны айлчлал хийх үеэр хоёр улсын хооронд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-г байгуулсан бөгөөд энэхүү гэрээ нь манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргаж, өнөөгийн харилцааны эрх зүйн үндэс болж байна.

Түүнээс хойш ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевын 2009 оны 8 дугаар сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол Улс, ОХУ хоорондын стратегийн түншлэл эрчимтэй өрнөж, хөгжлийн шинэ шатанд гарч буйг хоёр тал санал нэгтэй тэмдэглэж, “Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай Тунхаглалд” гарын үсэг зурсан билээ. Үүгээр Монгол Улс стратегийн түншлэлийн харилцааг анх ОХУ-тай тогтоосон бөгөөд энэ нь манай улсын бие даасан гадаад бодлого, хоёр талын харилцаандаа өгч буй ач холбогдлын илэрхийлэл болсон юм.

Манай улс өнөөдрийн байдлаар 2011 онд БНХАУ-тай, 2013 онд Япон Улстай “стратегийн түншлэлийн харилцаа”, 2014 онд БНХАУ-тай харилцааны түвшингээ дээшлүүлж “иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа” тус тус тогтоосон. ОХУ-тай хөгжиж буй харилцааны өнөөгийн түвшин болон Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу хоёр хөрштэй тэнцвэртэй харилцаа тогтоох үүднээс ОХУ-тай энэхүү гэрээг байгуулж, “иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа” тогтоох юм.

Гэрээний талаар

ОХУ-тай иж бүрэн стратегийн түншлэл тогтоож байгаатай холбогдуулан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын 1993 оны гэрээг шинэчилж байгаа болно. Одоогийн үйлчилж байгаа Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны 1993 оны гэрээ нь салбар бүрийг хамарсан 20 зүйлтэй бөгөөд харилцааны өнөөгийн байдалд нийцүүлж, монголын тал тус улстай байгуулсан олон улсын гэрээ болон хоёр талын нэгдэж орсон олон улсын конвенцын хүрээнд судалж, нэгэнт хоёр талын байгуулсан баримт бичигт туссан зарим зүйлийг найруулгын хувьд тодорхой болгосноор гэрээг эцэслэн тохиролцоод

байна.

Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны 1993 оны гэрээг шинэчилснээр Монгол, Оросын худалдаа, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, зам тээвэр, батлан хамгаалах зэрэг бүхий л салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хамтын ажиллагааны практик асуудлыг зохицуулах чухал ач холбогдолтой болох юм.

Энэхүү гэрээнд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2019 оны 9 дүгээр сард Монгол Улсад хийх төрийн айлчлалын үеэр хоёр улсын төрийн тэргүүн нар гарын үсэг зурахаар төлөвлөж байна. Тус гэрээний төслийг Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд шийдвэрлэсний дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР